

# ОРЧИН ҮЕИЙН КРИМИНОЛОГИЙН ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

## MODERN CRIMINOLOGY THEORY TRENDS AND REQUIREMENTS

*Э.Дашгаадан*

*ДХИС-ийн ЭШНХ-ийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ажилтан-багш, доктор (Ph.D), цагдаагийн ахмад*

**Товч агуулга:** Криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун нь гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлан тодорхой онош тогтоосны үндсэн дээр түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлох зорилготой байдаг. Эрдэмтэн, судлаачид олон жилийн турш боловсруулсан 200 гаруй гэмт явдлын онол энэ л зорилгын хүрээнд зөв механизмыг тогтоохын тулд олон модель, загварыг хэрэгжүүлсэн. Сүүлийн үеийн судлаачдын онолын талаар баримталж буй чиг хандлага нь нөлөө бүхий онолуудыг нэгтгэх буюу интеграци хийх байдлаар хөгжүүлж, гэмт явдлыг илүү өргөн цар хүрээнд авч үзэн шалтгаан, нөхцөлийг тогтоохоос илүүтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авахыг голчлон анхаардаг болжээ. Энэ өгүүлэлд криминологийн шинжлэх ухаанд гарч буй өөрчлөлт, хөгжлийг түүхэн цаг үетэй харьцуулан манай улсад тулгамдсан зарим асуудлыг хөндөж, үр нөлөөг хөгжүүлэх бодит санал дэвшүүлэхийг зорилоо.

**Abstract:** The main subject of criminology is to study the causes and conditions of crime, establish a specific diagnosis, and create effective ways to combat it. More than 200 theories of crime have been studied over the decades with this goal in mind, and countless models and models have been applied to explain the causes of crime and establish the correct mechanism. Recent trends in criminologists' theories have developed in a way that integrates influential theories and focuses on how to combat and prevent crime, rather than determining its causes, by looking at crime on a broader scale. In this article, we have compared the changes and developments in the science of criminology with historical times, and we aim to address some of the problems facing our country and make practical suggestions for the development of future effects.

**Түлхүүр үгс:** Гэмт хэрэг, гэмт хэргийн статистик, гэмт явдлын онолууд, гэмт явдлын хүчин зүйл, гэмт явдлын шалтгаан нөхцөл, зөрчил, интеграци, криминологи.

**Keywords:** Crime, crime statistics, theories of crime, factors of crime, causal conditions of crime, conflict, integration, criminology.

### 1.1.Криминологийн онолын ойлголт

Криминологи нь гэмт хэрэгт нөлөөлөх биологийн, сэтгэл зүйн, нийгмийн, экологийн болон бусад хүчин зүйл, шалтгааныг судалж, гэмт явдал хэрхэн үйлдэгддэг талаар таамаг дэвшүүлж, урьдчилан сэргийлэх арга зүйг бий болгодог шинжлэх ухааны салбар юм.

Түүхэн хөгжлийн явцаас харахад онолын түвшинд сонгодог үзэл баримтлалаар эхэлсэн бөгөөд гэмт бие хүнд тулгуурласан тайлбарууд гэмт хэргийг биологийн хүчин зүйлтэй холбон үргэлжилж, сүүлд нь 1970-аад оноос сонгодог үзэл баримтлал шинээр хүчээ авч эхэлсэн байдаг.

Гэмт явдал судлал нь сүүлийн 200 жил зогсолтгүй хөгжиж байгаа судалгааны чиглэл бөгөөд эдийн засаг, нийгэм, улс төрийн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хуучин онолоо үгүйсгэх байдлаар шинэчлэгдсээр иржээ.

Хот суурин газрууд бий болж, хүн амын тоо ихсэх үзэгдлийг дагаад шилжилт хөдөлгөөн, аж үйлдвэр, эдийн засгийн хямрал, I, II дайн, эдийн засгийн парадигм, түүний үр дүнд бий болсон капиталист буюу хувь хүн төвтэй нийгмийн тогтолцоо, феминист үзэл баримтлал, олон улсын харилцаа, даяаршил, барууны соёл дэлхий дахинд тархаж эхэлсэн зэрэг нь дэлхийн улс орнуудад хүчтэй нөлөө үзүүлсэн.

Эдгээрийг дагаад улс үндэстнүүд, нийгэм, хувь хүнд ч нөлөөлсөн бөгөөд гэмт явдлыг судлахад ч томоохон өөрчлөлт гарсан.

Криминологийн шинжлэх ухаанд олон салбарын эрдэмтэд хувь нэмрээ оруулсан. Тухайлбал, Эдвин Сатерланд<sup>45</sup>, Роберт Агнев<sup>46</sup>, Жереми Бентам<sup>47</sup>, Чезаре Беккариа<sup>48</sup>, Чезарь Ломброзо<sup>49</sup>, Зигмунд Фройд, Роберт Сампсон<sup>50</sup>, Родни Старк нарыг дурдаж болох юм.

Харин онолын интеграцийн ойлголтыг хөгжүүлэхэд Франк С.Пийрсон, Нейл А.Фейнэр, Томас Ж.Бернард, Жеффери Б.Снайпс, Травис Хирш, Теренс Торнберри, Делберт Эллиот нар голлох үүрэг гүйцэтгэсээр байна.

## 1.2. Онолын ангилал

Криминологийн шинжлэх ухаанаас урган гарсан онолууд нь таамаглал, төсөөллөөр хөгжсөн бөгөөд маш баялаг шинжлэх ухааны салбар болохыг харж болно.<sup>51</sup> Эдгээр нь ерөнхийдөө гэмт явдал, гэмт хэрэгтний хувийн онцлогийг судалдаг, нийгмийн болон экологийн шалтгаан, нөхцөлийг судалдаг гэх хоёр үндсэн ангилалд хуваагдаж байгаа<sup>52</sup> гэж судлаачид үзжээ.

Криминологийн анхны үзэл баримтлалын хувьд гэмт хэрэгтэн бие хүнийг тодорхойлохоор зорьж сонгодог үзэл баримтлалыг бий болгосон ба үүнээс рационал сонголтын онол нь хамгийн алдартай юм. Мөн тухайн үед ял шийтгэлийн ач холбогдлыг тодорхойлсон нь дэвшилт болжээ.

Улмаар гэмт явдлыг хувь хүний биологийн онцлогтой холбон тайлбарлах хандлагыг анагаах ухааны эрдэмтэд эхлүүлсэн нь бидний анхаарлыг маш их татдаг билээ. Тухайлбал, Ч.Ломброзо, В.Шелдон, Ч.Горинг нарын хүний биеийн галбир, яс, генийн содон шинжийг харьцуулж, гэмт хэрэгтэн бие хүний онцлогийг судалж байсан судалгаа нь өнөөдрийг хүртэл маргаан дагуулсаар байдаг.

Мөн сэтгэл зүйн шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан Ж.Пиаже, З.Фройд нарын онолын үндсэн ойлголтыг гэмт явдлын шалтгааныг тайлбарлахад ашиглах хандлага бий болсон нь хувь хүний онцлог талаас нь судалсан шинэлэг хандлага юм.

Үүнээс гадна, гэмт явдлын экологийн онолууд хөгжиж эхэлсэн нь зөвхөн бие хүнээс шалтгаалахгүй болохыг батлан харуулсан хэрэг болсон. Тухайлбал, нийгмийн буюу социологийн онол, суралцахуйн онол, хяналтын онол, аноми, дэд соёлын онол, шошгололтын онол, зөрчилдөөний буюу радикал онолууд, феминист онол зэрэг нь олон ургалч үзлийг криминологид бий болгож байгаа тод илрэл мөн.

## 2.1. Нийлмэл онолын ойлголт, хэрэгцээ, шаардлага

Гэмт явдал нь нийгмийн өвөрмөц үзэгдэл бөгөөд цөөнгүй хүчин зүйл нөлөөлдөг тул түүний шалтгааныг тогтоохын тулд олон талаас нь авч үзэх шаардлагатай. Үүнээс үзвэл, ялгаатай онолуудын давуу талыг нэгтгэн шинэ загвар бий болгох нь гэмт хэргийн бүтцийг илүү тодорхой болгох нь эргэлзээгүй.

Гэмт явдал нь ганцхан хүчин зүйлийн нөлөөнд бий болдог үзэгдэл биш юм. Ихэнх эрдэмтэд гэмт явдлын онолууд хэт их болсон нь шинжлэх ухаанд эмх замбараагүй байдлыг болгож байна гэж үзсэн бол Волд, Бернард, Снайпс зэрэг

<sup>45</sup> Sutherland, Edwin H and Crossey, Donald R. 1978. Criminology. 10th Edition. Philadelphia, New York, San Jose, Toronto: J. B. Lippincott Company.

<sup>46</sup> Agnew, Robert. 1985. A Revised Strain Theory of Delinquency. Social Forces, Vol.64.

<sup>47</sup> Bentham, Jeremy and Bozovic, Miran. 1995. The Panopticon Writings, London, New York: Verso.

<sup>48</sup> Beccaria, Cesare. 1963. On crimes and Punishment, trans. H. Paolucci. Indianapolis, IN; Bobbs-Merill.

<sup>49</sup> Lombroso, Cesare. 1876. L'Uomo Delinquente. Milan: Hoepli.

<sup>50</sup> Sampson, Robert J and Wilson, William J. 2003. "A Theory of Race, Crime and Urban inequality." In Francis T.Cullen and Robert Agnew, Criminological Theory: Essential Readings – Past to Present, 2nd Edition. Los Angeles, CA: Roxbury Publishing Company.

<sup>51</sup> Cohen, Lawrence E. and Siegel, Larry. 1996. Readings in Contemporary Criminological Theory. Boston; Northeastern University Press.

<sup>52</sup> Sumner, Colin. 2004. "The Social Nature of Crime and Deviance" in Colin Sumner /ed./ The Blackwell Companion to Criminology. Madlen, MA; Blackwell Publishing, pp.3-31.

эрдэмтэд энэ нөхцөл байдлыг харин ч давуу тал гэж үзсэн. Онолууд маш олон байгаа шалтгаан нь судлах асуудал олон төрөл байгаатай холбоотой ба нэг парадигмаар тодорхойлох аргагүй байдагтай холбоотой.

Зарим криминологичид онолуудыг нэгтгэх туршилтыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэжээ. Үүнээс гадна ялгаатай судлагдахуун бүхий онолуудыг өрсөлдүүлэх боломжгүй ба ижил судлагдахуунтай онолууд өрсөлдөх биш нэгнийхээ дутууг нөхөх нөлөөтэй юм.<sup>53</sup> Үүнээс үзвэл, онолуудыг нэгтгэх нь онолуудын тоог багасгахын зэрэгцээ илүү үр нөлөөтэй онолын загварыг бий болгох боломжтой.

## 2.2. Онолыг нэгтгэх хэлбэр:

Онолыг нэгтгэх үндсэн хоёр төрлийн арга байдаг. Үүнд:

1. Үзэл баримтлалын нэгдэл;
2. Үзэл санааны нэгдэл.

Үзэл баримтлалын нэгдлээр ялгаатай онолын загваруудыг нэгтгэн шинээр загварчлан онолын модель бий болгодог. Тухайлбал, Эйкэрсийн 1985, 1998 оны нийгмийн суралцахуйн онол /social learning theory/, Брайтвейтийн 2005 оны нэгтгэгч зэмлэлийн онол /reintegrative shaming theory/, Күллений 1994 оны нийгмийн дэмжлэгийн онол /social support theory/, Титлийн 1995 оны хяналт тэнцвэрийн онол /control-balance theory/ зэрэг нь үзэл баримтлалын нэгдлийн тод жишээ юм.

Үзэл санааны нэгдэл нь ялгаатай үзэл санааг аль нэг онолын бүтцэд оруулж, системтэйгээр харилцан нөхөх байдлаар хэрэгждэг.

Энэ нь ихэвчлэн дараах гурван төрлийн моделийг ашигладаг:

1. Үечлэн нэгтгэл/end to end integration/
2. Зэрэгцээ нэгдэл /Side to side integration/
3. Шаталсан нэгдэл /up and down integration/

### 2.2.1 Үечлэн нэгтгэх

Энэ тохиолдол нь өөр онолын үзлээр дэвшүүлсэн санааг нэг нэгнийх нь үзүүртэй холбодог онолын загвар юм. Өөрөөр хэлбэл аливаа нэг онолын үзэл санаа өөр нэг онолын өмнөх үе шат болно.

#### Үечлэн нэгтгэх

А онол	:	X → Y
Б онол	:	Y → Z
Нийлмэл онол	:	X → Y → Z

Онолуудыг үечлэн нэгтгэсэн тод жишээ бол Эллиот нарын судлаачид 1979 онд гажуудлын онол, нийгмийн хяналтын онол ба суралцахуйн онолыг ар араас нь цувруулан гэмт хэрэг, гэм буруутай үйлдлийг тодорхойлжээ. Юуны өмнө гэр бүлийн хүрээнд эсвэл сургуулийн орчинд үүсэх гажуудал хувь хүний нийгмийн харилцааг сулруулдаг. Энэ нөхцөл байдал нь нийгмээс тусгаарлан гэмт хэргийн хамаарал бүхий хүмүүстэй дотносон, тэдгээрийг даган дуурайж, аажмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг<sup>54</sup> гэжээ.

### 2.2.2. Зэрэгцээ нэгдэл

Зэрэгцээ нэгдэл нь тодорхой нэг гэмт хэрэг эсвэл зөрчлийн төрлийг тодорхойлсон онолуудыг зэрэгцүүлж, аль аль онолынх нь тодорхойлогч хувьсагчийг нэгтгэн илүү өргөн цар хүрээтэй загварыг бий болгох юм. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгдэхэд эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлдөг гэх онолын загвартай боловсрол

<sup>53</sup> Vold, George B, Bernard, Thomas J and Snipes, Jeffrey B. 1998. Theoretical Criminology. 4<sup>th</sup> Edition. New York: Oxford University Press.

<sup>54</sup> Elliot, Delbert S. Ageton, Suzanne S and Canter, Rachelle J. 1979. "An Integrated Theoretical Perspective on Delinquent Behavior." Journal of Research in Crime and Delinquency, Vol.16, No.1, pp.3-27.


ба гэмт хэргийн хамаарлыг судалдаг өөр нэг онолыг нэгтгэн гэмт хэрэгт эдийн засгийн ба боловсролын асуудал хамт нөлөөлдөг гэх шинэ модель гаргаж ирэх нь энэ төрлийн нэгдэлд хамаарна.

*Зэрэгцээ нэгдлийн механизм*

А онол	:	$Y=X1+X2+Z1$
Б онол	:	$Y=Z1+Z2+W1$
Нийлмэл онол	:	$Y=X1+X2+Z1+Z2+W1$

Зэрэгцээ нэгдлийн тод жишээ бол Торнберригийн 1987 оны нийлмэл онол юм. Нийгмийн хяналтын онол, суралцахуйн онол зэрэг онолууд гэмт хэргийг дангаараа тодорхойлоход хангалтгүй ба гэмт хэргийн механизм нь маш олон төрлийн харилцаанд үүсдэг ч эдгээр онолууд хамаарах хүчин зүйлийг бүтэн хүрээгээр нь авч үзэж чадаагүй юм<sup>55</sup>.

Торнберригийн нийлмэл онолын загвар



2.2.3. Шаталсан нэгдэл

Энэ ойлголтоор өөр өөр түвшний онолын загварыг нэг дор авчран харилцан нэгтгэж, шинэ модель гаргаж авдаг. Тухайлбал, гэмт хэргийн түвшнийг макро түвшний хувьсагчаар тодорхойлох гэж оролдож байгаа онолд нийгмийн хүчин зүйл, гэм буруутай зан үйлийг хувь хүний хүчин зүйлээр тодорхойлохоор оролдох микро түвшний онолын гэмт хэрэгт нөлөөлдөг хувьсагчуудыг нэмэгдүүлсэн модель байж болно.

*Шаталсан нэгдлийн механизм*

Макро онол	:	$Y1=X1+X2+Z1$ /Гэмт хэргийн түвшин/
Микро онол	:	$Y2=A+B+W$ /Гэмт хэрэг/
Нийлмэл онол	:	$Y3= A+B+W+X1+X2+Z1$ +хувьсагч

Колвин ба Паули нарын 1983 оны “Марксист бүтцийн онол” нь шаталсан нэгдлийн стратегийн тод жишээ юм.


3.1.Криминологийн нийлмэл онолын хэрэгжилтэд тулгамдсан асуудал

Монгол Улс дахь гэмт хэргийн төлөв байдал, чиг хандлагаас үзэхэд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шалтгаан гэж шууд хэлэхээс илүүтэй төр засгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримталж буй бодлого, Эрүүгийн хуультай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг ч хийж болохоор байна. Иймд тухайн нийгэм дэх сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн тулд сөрөг гэж үзэж буй нийгмийн харилцаатай тэмцэх, арилгахын тулд

<sup>55</sup> Thornberry, Terence P. Lizotte, Alan J. Krohn, Marvin D. Farnworth Margaret and Jang Sung. 1994. “Delinquent Peers, Beliefs and Delinquent Behavior: A Longitudinal Test of Interaction Theory.” Criminology. Vol.32, No.1, pp.47-83.

Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох нь гэмт үзэгдлийн чиг хандлагад шууд хамааралтай гэж үзсээр ирсэн нь гэмт явдлын шалтгааныг тогтоох нэг талын өнцөг юм.

Зураг №1. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо. (1990-2022 он)



Эрүүгийн хууль, бусад холбогдох хууль тогтоомж өөрчлөгдөн шинэчлэгдсээр байгаа хэдий ч гэмт хэргийн түвшин жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа нь нууц биш юм.

Гэмт хэргийн түвшин өссөөр байгаа энэ үзэгдлийг хэд хэдэн шалтгаантай холбон тайлбарладаг. Тухайлбал, гэмт хэргийн статистикийг өмнө нь бүрэн ашигладаггүй байсан, орчин үеийн техник технологийн хөгжил, хотжилт, иргэдийн ухамсар, ёс зүй өөрчлөгдсөн зэргийг дурдаж болно.

Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн статистик, шийдвэрлэлийн талаарх гэмт хэргийн цагаан номыг олон улсын жишигт нийцүүлэн 2016 оноос жил бүр гаргаж байгаа нь сайшаалтай. Энэ нь олон байгууллагын статистикийг нэгтгэж чадсан бөгөөд цаашид улам боловсронгуй болох шаардлага бий болжээ. Тухайлбал, гэмт хэргийн түвшин, өөрчлөлт, газар нутгийн байршил зэргийн цаашдын чиг хандлагыг хэт ерөнхий байдлаар гаргаж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилыг тодорхойлоход хангалтгүй байна. Жишээ нь, 2022 онд орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 843 буюу 7.7 хувийг Хөвсгөл аймагт, 775 буюу 7.0 хувийг Сэлэнгэ аймагт, 754 буюу 6.8 хувь нь Төв аймагт, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6293 буюу 25.9 хувийг Баянзүрх дүүрэгт, 4523 буюу 18.6 хувийг Баянгол дүүрэгт, 3626 буюу 14.9 хувийг Сүхбаатар дүүрэгт тус тус бүртгэгдсэн нь хамгийн их байна гэх зэрэг агуулга нь зөвхөн мэдээ мэдээллийн шинжтэй юм.

Монгол Улсын хувьд жил бүр үйлдэгдэж буй гэмт хэргийн ангиллаар авч үзвэл, нийт гэмт хэргийн 60 орчим хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30 орчим хувийг хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 5 орчим хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлдэг. Энэ нөхцөл байдал сүүлийн 10 жил огт өөрчлөгдөөгүй нь гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээг авч чадахгүй байгаагийн илрэл юм.


Үүнээс үзвэл, гэмт хэргийн статистикт тулгуурлан урьдчилан сэргийлэхдээ тухайн гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгааныг нарийвчлан бүртгэн судлах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд судалгаа хийж хэвших шаардлагатай юм. Өнөөгийн байдлаар гэмт хэрэг үйлдсэн байдлыг согтуугаар, эмэгтэй хүн үйлдсэн, бүлэглэн, гэр бүлийн хүчирхийллийн улмаас, хүүхэд оролцсон гэсэн хэдхэн ерөнхий нөхцөлөөр хязгаарлаж байна.

Зураг №2. 2013-2022 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 16 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд ногдох хэрэг.



Албан ёсны статистикийн мэдээлэлд үндэслэн тооцоолоход жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 10,000 хүнд 115, 100,000 хүнд 1153 гэмт хэрэг, 18 ба түүнээс дээш насны 10,000 хүнд 122, 100 000 хүнд 1219 гэмт хэрэг тус тус оногдож байгаа нь Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах үзүүлэлт болно. Үүнээс үзэхэд хүн ам цөөн, гэмт хэргийн түвшин өндөр, түүнээс үүссэн хор уршиг, хохирол харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна.<sup>56</sup>

Зураг №3. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс.



Гэмт хэргийн үзүүлэлтийн төлөв байдлаас үзэхэд, дэлхий дахинд үйлдэгдэж буй гэмт үзэгдэл өсөж байна. Тодруулбал, сүүлийн 30-40 жилд гэмт үзэгдэл дунджаар 3-4 дахин өсжээ. ОХУ-д 6-8 дахин, АНУ-д 7-8 дахин, Англи, Швейцарт 6-7 дахин, Францад 5-6 дахин, Германд 3-4 дахин, Японд 1.5-2 дахин гэмт үзэгдэл өссөн байна.<sup>57</sup>

Үүнээс үзвэл, гэмт хэрэгт холбогдож буй этгээдүүдийн криминологи судалгаа хийх зайлшгүй шаардлагатай юм. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, эмэгтэй хүн оролцсон хэрэг, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг, хүүхэд оролцсон хэрэг, бүлэглэн үйлдсэн хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, галт зэвсгээр үйлдсэн хэрэг

<sup>56</sup> Үндэсний статистикийн хороо. URL: [www.1212.mn](http://www.1212.mn).

<sup>57</sup> Болдбаатар Ж., Нямдаваа О. Криминологи. УБ. 2010. 34 дэх тал.

өмнөх оноос хэрхэн өссөн, эсвэл буурсан гэдгийг тоочихоос илүү энэ төрлийн нөхцөл байдал бий болж буй шалтгааныг тодруулах нь зүйтэй.

Криминологи судалгаа нь зөвхөн цагдаагийн байгууллагын хийж, гүйцэтгэх үүрэг, чиглэлд хамаарахгүй өргөн цар хүрээний ойлголт тул нийгмийн бусад салбарыг оролцуулах, эргээд урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитой зохион байгуулах нь хамгийн чухал юм.

Үүнээс гадна криминологийн шинжлэх ухааныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэж явцуу утгаар нь ойлгодог хандлагаас татгалзаж, онолын шинэ үзэл баримтлалыг судалгааны эргэлтэд оруулж, практик байгууллагуудтай хамтран туршилт, судалгаа хийж, хөгжүүлэх нь энэ салбарт дутагдаж байна. Мөн манай орны хувьд криминологийн зарим онол залуу судлаачдын сонирхлыг ихээхэн татсаар байдаг ба үүнд хэт автаж, зөвхөн нэг талын шалтгааныг судлах, эсвэл аль эрт няцаагдсан онолыг туршиж, нийгэмд төөрөгдөл үүсгэх муйхар дүгнэлтийг гаргах нөхцөл бүрдээд байгаа нь анхаарууштай байдлын нэг болжээ. Тухайлбал, гэмт хэрэгтэн бие хүнийг тодорхойлох генийн буюу биеийн бүтцийн судалгаа, гарын мөрийн судалгаа зэрэг нь алдарт Ломброззогийн 1800 оны сүүлийн хагаст туршиж байсан судалгаа төдийгүй хожим бусад судлаачдын зүгээс судалгааны түүврийг хэт туйлшруулж, таамгаа батлахаар оролдсон гэж шүүмжлүүлсэн билээ.

Манай улсын криминологийн салбарт энэ мэт онолууд шинэ тутам мэт байгаа нь судлах, турших маш том салбар гэдгийг илтгэж байгаа төдийгүй мэргэжлийн криминологич бэлтгэгдэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

### **Дүгнэлт**

Криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун нь гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлан түүнтэй тэмцэх, үр өгөөжтэй арга зам бий болгох зорилготой байдаг төдийгүй тоологдошгүй олон загварыг хэрэгжүүлсэн ба цаашид улам боловсронгуй болон хөгжсөөр байна. Сонгодог үзэл баримтлалаас эхлээд позитивист үзэл баримтлалын биологи, психологи ба социологийн үзэл хандлагаар үргэлжилж, шошгололт болон зөрчилдөөнт холбоо зэрэг онолуудаар баяжиж байгаа боловч ерөнхий агуулгаараа гэмт хэрэгтний хувийн байдал болон экологийн шалтгаан, нөхцөлд суурилсан онолын урсгал байна гэж үзлээ.

Гэмт явдал нь нийгмийн хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалдаг өвөрмөц үзэгдэл тул онолууд нэг нэгнийхээ дутууг нөхөн нийлмэл шинжийг агуулах шаардлага бий болсон ба хэд хэдэн арга хэлбэртэй байдаг нь судалгаагаар тогтоогдсон. Монгол улсад бүртгэгдэж буй гэмт хэргийн статистик, шийдвэрлэлийн талаарх гэмт хэргийн цагаан номыг олон улсын жишигт нийцүүлэн 2016 оноос жил бүр гаргаж байгаа нь сайшаалтай. Энэ нь олон байгууллагын статистикийг нэгтгэж чадсан ч цаашид гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шинжлэх ухаанчаар хандах асуудал дутагдаж байна.

Онол-судалгаа-хэрэгжүүлэлт-дүгнэлт гэсэн гинжин холбоог ягштал баримтлан, онол ба практикийг хослуулах, эрдэмтэн, судлаачдын болон практик байгууллагуудын хамтын ажиллагааны сувгийг байгуулах нь чухал. Холимог, олон талт шинжтэй гэмт явдалтай тэмцэх нь хэдхэн хүний яриад, шийдвэрлэх асуудал биш юм. Учир нь криминологигүйгээр гэмт явдалтай тэмцэх боломжгүй.

Криминологийн түүхэн зарим онол залуу судлаачдын сонирхлыг ихээхэн татсаар байдаг ба үүнд хэт автаж, зөвхөн нэг талын шалтгааныг судлах, эсвэл аль эрт няцаагдсан онолыг туршиж, нийгэмд төөрөгдөл үүсгэх муйхар дүгнэлтийг гаргах нөхцөл бүрдээд байгаа нь анхаарууштай байдлын нэг болжээ.

### **Санал**

Судалгааны үр дүн, түүний эцэст хийсэн дүгнэлтэд түшиглэн цаашид криминологийн шинжлэх ухааны онолын үзэл баримтлал, чиг хандлагад суурилан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлэхэд ашиглах, харилцан уялдааг хангах үүднээс дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

1. Криминологийн орчин үеийн онолын чиг хандлагыг энэ төрлийн судлаачдын дунд нэвтрүүлэн түгээж, эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, гэмт хэргийн түвшин, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаатай хэрхэн зохиож байгаатай уялдуулах, рационал үзэл баримтлалыг нэвтрүүлэх;

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн статистик мэдээллийг харилцан солилцож буй байгууллагууд тухайн гэмт хэргийн шалтгааныг судлах, нарийвчилсан дүн мэдээг харилцан солилцож хэвших;

3. Криминологи судалгаа нь зөвхөн цагдаагийн байгууллагын хийж, гүйцэтгэх үүрэг, чиглэлд хамаарахгүй өргөн цар хүрээний ойлголт тул нийгмийн бусад салбарыг оролцуулах, эргээд урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитой зохион байгуулах нь хамгийн чухал бөгөөд бүх салбар шинжлэх ухаантай хослуулж, байнга хөгжүүлж, боломжит хамрах хүрээнд нь ашиглах шаардлагатай;

4. Криминологийн шинжлэх ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны эрэлт хэрэгцээнд тулгуурлан энэ төрлийн мэргэжилтэн бэлтгэж, салбаруудын хамтын ажиллагаанд хэрэгжүүлэх;

5. Криминологийн онолын орчин үеийн хандлагыг судлан практикт хэрэгжүүлэх боломжийг судлах шаардлагатай бөгөөд хэт туйлширсан буюу үр дүнгүй зарим онолын үзэл баримтлалаас татгалзах, судалгаагүй урьдчилан сэргийлэх ажилд төсөв, хөрөнгө зарцуулахаас зайлсхийх шаардлагатай.

#### **Ашигласан материал**

1. Болдбаатар Ж., Нямдаваа О. Криминологи. УБ. 2010.
2. Sutherland, Edwin H and Crossey, Donald R. 1978. Criminology. 10th Edition. Philadelphia, New York, San Jose, Toronto: J. B. Lippincott Company.
3. Agnew, Robert. 1985. A Revised Strain Theory of Delinquency. Social Forces, Vol.64.
4. Bentham, Jeremy and Bozovic, Miran. 1995. The Panopticon Writings, London, New York: Verso.
5. Beccaria, Cesare. 1963. On crimes and Punishment, trans. H. Paolucci. Indianapolis, IN; Bobbs-Merill.
6. Lombroso, Cesare. 1876. L'Uomo Delinquente. Milan: Hoepli.
7. Sampson, Robert J and Wilson, William J. 2003. "A Theory of Race, Crime and Urban inequality." In Francis T.Cullen and Robert Agnew, Criminological Theory: Essential Readings – Past to Present, 2nd Edition. Los Angeles, CA: Roxbury Publishing Company
8. Cohen, Lawrence E. and Siegel, Larry. 1996. Readings in Contemporary Criminological Theory. Boston; Northeastern University Press.
9. Sumner, Colin. 2004. "The Social Nature of Crime and Deviance" in Colin Sumner /ed./ The Blackwell Companion to Criminology. Madlen, MA; Blackwell Publishing
10. Vold, George B, Bernard, Thomas J and Snipes, Jefferey B. 1998. Theoretical Criminology. 4<sup>th</sup> Edition. New York: Oxford University Press.
11. Elliot, Delbert S. Ageton, Suzanne S and Canter, Rachelle J. 1979. "An Integrated Theoretical Perspective on Delinquent Behavior." Journal of Research in Crime and Delinquency, Vol.16, No.1.
12. Thornberry, Terence P. Lizotte, Alan J. Krohn, Marvin D. Farnworth Margaret and Jang Sung. 1994. "Delinquent Peers, Beliefs and Delinquent Behavior: A Longitudinal Test of Interaction Theory." Criminology. Vol.32, No.1.
13. Үндэсний статистикийн хорооны мэдээ. URL: [www.1212.mn](http://www.1212.mn).